

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур		Биелэлт
		Хугацаа	Гүйцэтгэлийн үзүүлэлт	
1	Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах		Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1	
1.1	Төрийн байгууллагад мөрдөгдөж буй хүнд суртал, чирэгдэл учруулсан дүрэм журмыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох ажлыг зохион байгуулах	Жилдээ	<p>МТШХХГ нь 2014 оныг Хууль, эрх зүйн шинэчлэлийн жил болгосонтой холбогдуулан шинээр өргөн барих, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж, олон нийтээр хэлэлцүүлэн, Дээд газарт хүргүүлэх Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. МХХ-ны салбарын бодлогын баримт бичиг - 2020 2. Шинээр боловсруулах хуулийн төсөл <ul style="list-style-type: none"> • Өргөн нэвтрүүлгийн тухай хууль • Өгөгдөл хамгаалах тухай хууль 3. Шинэчилсэн найруулга боловсруулах хуулийн төсөл <ul style="list-style-type: none"> • Харилцаа холбооны тухай хууль • Шуудангийн тухай хууль • Радио долгионы тухай хууль 4. Салбарт мөрдөж байгаа журмуудыг шинэчлэх <p>Хууль болон бусад шийдвэрийн төсөлд санал авч, үр дүнг олон нийтэд мэдээлэх /цахим хуудас, санал асуулга г.м/</p> <p>Тухайн жилд хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад орсон хууль, УИХ-ын шийдвэрийг олон нийтээр хэлэлцүүлсэн байдал</p> <p>Иргэд, ТББ-ын саналыг хууль болон шийдвэрийн төсөлд тусгасан байдал</p> <p>Байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын нээлттэй мэдээлэх</p> <p>“Мэдээллийн ил тод байдлыг хангах журам”-ын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудсыг шинэчлэн гаргаж, мэдээллийг ил тод байршуулах</p>	<p>МТШХХГ нь 2014 оныг Хууль, эрх зүйн шинэчлэлийн жил болгосонтой холбогдуулан олон нийт, салбар болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад танилцуулах зорилгоор Төрийн ордонд 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр “Эрх зүйн шинэчлэл-2014” нээлттэй өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт бүх яам, агентлаг, төрийн болон төрийн бус нийт 160 гаруй байгууллагаас 900 орчим төлөөлөгчид оролцлоо.</p> <p>Энэ онд шинээр боловсруулах болон нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж, олон нийтээр хэлэлцүүлж байна. Үүнд: “Өгөгдөл хамгаалах тухай” хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг олон нийтээр хэлэлцүүлэх зорилгоор нээлттэй хэлэлцүүлгийг Мэдээлэл технологийн үндэсний парсад 2014 оны 10 дугаар сарын 8-ны өдөр зохион байгуулав. Энэхүү хэлэлцүүлгээр хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагын өгөгдлийг хэрхэн боловсруулах, бүртгэх, ашиглах, хадгалах, дамжуулах, шилжүүлэх зэргээр мэдээллийн эргэлтэд оруулах процесстой холбоотойгоор үйлчилгээ эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлууд, түүний хуулийн зохицуулалтын талаар харилцан санал солилцлоо</p> <p>“Өргөн нэвтрүүлгийн тухай” хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, хоёр дахь хэлэлцүүлгийг 2014 оны 10 дугаар сарын 9-ний өдөр телевиз импортлогч байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн байгууллагуудын хүрээнд зохион байгууллаа. Үзэл баримтлалын төслийг батлуулахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газраас санал авахаар бэлтгэж байна. /Хавсралт/</p> <p>Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх аливаа тушаал шийдвэрийн төслийг холбогдох дарга нарт</p>

				<p>танилцуулж, саналыг нь авсаны үндсэн дээр баталгаажуулж байгаа бөгөөд салбарын хэмжээнд болон нийтээр дагаж мөрдөх шаардлагатай шийдвэрүүдийг цахим хуудасанд тухай бүр байрлуулан ажиллаж байна.</p> <p>Мэдээллийн ил тод байдлыг хангах журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын цахим хуудсыг тогтмол шинэчлэн Худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал, Төсөв, санхүүгийн ил тод байдал, Үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал, салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, шаардлагатай маягт болон 2014 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөр, төсөвт өртгийн сар улирлын мэдээ зэрэг мэдээллийг байгууллагын www.itpta.gov.mn цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.</p> <p>Тус газар нь салбарын үйл ажиллагаа хийж хэрэгжүүлж байгаа ажил, төсөл хөтөлбөрүүд болон бусад холбогдох мэдээ мэдээллийг олон нийтэд таниулахаар мэдээ, мэдээлэл бэлтгэн байгууллагын www.itpta.gov.mn цахим хуудас, фэйсбүүк хуудаснаа байршуулан ажиллаж байна. /хавсралт/</p>
2	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх Эрх зүйн үндэслэл: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2</p>			
2.1	<p>Авлигын эсрэг 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөө</p>	2 сар	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, АТГ-т хүргүүлэх	<p>Тус газрын 2014 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан АТГ-т 2014.01.08-ны өдрийн 1/31 албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Тус газарт 2012 оны 8 дугаар сарын 15-наас 2014 оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд Авлигатай тэмцэх газраас хуулийн хэрэгжилт, боловсон хүчний бодлого зэрэг бүхий л асуудлаар ирүүлсэн болон хүргүүлсэн хариу албан бичиг, бусад хамаарал бүхий баримтуудын хуулбарыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2014 оны 8 дугаар сарын 8-ны өдөр 5/791 дугаарын албан бичгээр хүргүүлсэн</p>
3-р улирал		Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажиллах		
11 сар		Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлагналт, хүрсэн үр дүн		
3	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2</p>			
3.1	Газрын хэмжээнд Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах	Жилдээ	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/	Тус газар нь авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм, журмыг дотоод сүлжээ, байгууллагын веб сайтад байршуулан, мөрдлөг болгон ажиллаж байна.

			<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллагад түгээн ажилласан байдал</p>	<p>Газрын албан хаагчдын өрөө тасалгаанд болон харьяа байгууллагуудад Авлигын эсрэг зурагт хуудсыг байршуулж холбогдох гарын авлага материалыг хүргүүллээ.</p>
			<p>Дээд газрын тогтоол шийдвэрийг олон нийтэд ил тод нээлттэй байлгах</p>	<p>Тайлант хугацаанд нь дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг гарган, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Мөн олон нийтэд ил тод нээлттэй байлгах зорилгоор байгууллагын www.itpta.gov.mn цахим хуудсанд байршуулж байна.</p>
4	<p>Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3</p>			
4.1	<p>Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах шударга ёсыг төлөвшүүлэх</p>	1-р улирал	<p>Тухайн жилд МТШХХГ-аас явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөлтийг гарган, батлуулж ажиллах</p>	<p>Тус газрын даргын 2014 оны 1 дүгээр сарын 13-ний өдрийн 13 дугаар тушаалаар харьяа РТС УТҮГ, МТҮП, УДТ УТҮГ зэрэг байгууллагуудын 2013 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг 2014 оны 1 дүгээр сарын 16,17,20-ны өдрүүдэд удирдамжийн дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийн ажиллав. /Хийсэн ажлын тайланг хавсралтаар/ Холбогдох зөвлөмжийг дээрх байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Салбарын болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх журам"-ын төслийг боловсруулан Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гарсан шийдвэр зөвлөмжийг нэмж шинэчлэн боловсруулж байна.</p>
Жилдээ		<p>Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байдал</p> <p>Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ тус бүрийг МТШХХГ-ын Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/</p>		
1-р улирал		<p>Харьяа байгууллагын 2014 оны үйл ажиллагаанд Хяналт шинжилгээ үнэлгээ хийх / УДТ, МТҮП, РТС УТҮГ/</p>		
Жилдээ		<p>ЗГ-ын 2013 оны 322 тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд МТШХХГ-ын Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний журмыг шинэчлэн боловсруулж, батлуулан мөрдөж ажиллах</p>		
5	<p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл</p>			
5.1	<p>Байгууллагын төсвийн орлого түүний зарцуулалтын ил тод, хариуцлагатай байдлыг хангах</p>	Жилдээ	<p>Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд байршуулан олон нийт мэдээллийг нээлттэй мэдээлэх</p>	<p>Тус газрын 2014 оны санхүүжилтийн хуваарь болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр нь цахим хуудсанд байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээлж байна./хавсралт/</p> <p>Тус газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийлгэсэн гэрчилгээг байгууллагын</p>
<p>Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх</p>				
<p>Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулна.</p>				
<p>Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг тогтмол мэдээлэх</p>				

			<p>Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчилэн гаргаж, олон нийтэд мэдээлнэ.</p>	<p>цахим хуудсанд бүрэн эхээр нь байршуулсан./хавсралт/ Тус газраас 2014 онд Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг, ЗГНын 2009 оны 164 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинэхэн албан хаагчид нэг удаагийн тусламж олгох тухай журам”-ын 3 дахь заалтыг үндэслэн Ж.Баатархүүг төрийн албанаас чөлөөлж, байгууллагын тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас 22.973.112 төгрөгийг олгосон. /Тушаалын хавсралт/ Тус газарт 2014 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн мэдээллийг дээд газарт тогтмол хүргүүлэн ажиллаж байна./хавсралт/</p>
6	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл</p>			
6..1	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах	Тухай бүрд нь	<p>Сул орон тоо, гадаадын урт хугацааны сургалтын зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулна. /тухай бүр шинэчилсэн/</p>	<p>Тус газрын цахим хуудсанд тухайн жилийн сул орон тооны сонгон шалгаруулалтын зарын мэдээллийг байршуулан, олон нийтэд тогтмол мэдээлж ажилласан. Төрийн албаны зөвлөл рүү ажлын байрны сул орон тооны захиалгыг хүргүүлэн тус зөвлөлийн цахим хуудсаар мөн нээлттэй зарласан.</p> <p>Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтын зарыг тухай бүрт нь байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. /Хавсралт/</p> <p>Сансрын технологийн хөгжлийг дэмжих, хүний нөөцийг чадавхижуулах зорилгоор Ази-Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллаж “Сансрын технологийн хэрэглээ” чиглэлээр Докторын болон магистрийн зэрэг олгох тэтгэлэгт хөтөлбөрийг 6 дахь жилдээ зохион байгуулж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд МТШХХГ-аас дээрх хөтөлбөрийг нээлттэй зарласан бөгөөд 3 шатны сонгон шалгаруулалт явуулж, шалгалтанд тэнцсэн .ОБЕГ, Шинэ дэлхий телевиз, Газар зүйн хүрээлэн зэрэг байгууллагын. албан хаагчтай урт хугацааны сургалтын гэрээ байгуулаад байна.</p>
			<p>Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байдал</p>	<p>Тус газрын даргын 2013.10.14-ний өдрийн 245 дүгээр тушаалаар Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын төрийн албан хаагчийн сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөрийг</p>

			<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг олон нийтэд нээлттэй мэдээлэх</p>	<p>баталсан ба 2014 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Албан хаагчдад зориулан “Мэдээллийн цаг” хөтөлбөрийг долоо хоног бүрийн Баасан гаригт төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажилладаг.</p> <p>“Мэдээллийн цаг” хөтөлбөр болон тухайн жилийн сургалтын төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцэст гарган сургалтын хэрэгцээнд тулгуурлан ирэх жилийн төлөвлөгөөг жил бүр боловсруулан ажиллаж байна./хавсралт/</p> <p>Гадаадын ижил төстэй хамтын ажиллагаатай байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, семинар, хурал бусад арга хэмжээнд давхардсан тоогоор энэ онд нийт 55 албан хаагчийг хамрууллаа</p>
		<p>Хагас жил, жилийн эцэс</p>	<p>МТШХХГ-ын албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэх дүгнэх журмын гүйцэтгэлийг үнэлэх, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх</p>	<p>Тус газрын нийт албан хаагчдын хөдөлмөрийн сахилга, хариуцлагыг бэхжүүлэх, ажлын цаг ашиглалтыг нэмэгдүүлэх, цаг бүртгэлийн хяналтын системийг хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор ажлын цагын хяналт тавих журмыг 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 111 дугаар тушаалаар батлан, журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Тус газрын даргын 2012 оны 89 дүгээр тушаалаар батлагдсан “Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын хоёрдугаар хавсралтад “Маягт 10. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газарт туршилтын хугацаагаар ажиллаж байгаа мэргэжилтний ажлыг дүгнэх хуудас”-ын дагуу туршилтын хугацаа дууссан албан хаагчдыг үнэлж дүгнэж, холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байна. /Хавсралт/</p> <p>Тус газрын Эрх бүхий албан тушаалтан Б.Болормаа нь газрын даргын 2013 оны 08 дугаар тушаалаар үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдэл тооцон томилон одоог хүртэл ажиллаж байна. /хавсралтаар тушаалын хуулбар, ажлын байрны тодорхойлолт/</p>
		<p>1-р улирал</p>	<p>Байгууллагын албан хаагчдын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах</p>	<p>Хүнд суртал чирэгдэлгүй, мэдээллийг хүртээмжтэй болгох, үйл ажиллагаанд ил тод байдлыг ханган ажиллах зорилгоор газрын болон хэлтсийн дарга нар болон мэргэжилтнүүдийн эрхлэх ажил үүрэг, ерөөний дугаар, зэргийг тодорхой бичин, байгууллагын цахим хуудсанд байршуулаад байна</p>

7	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5</p>			
7.1	<p>Бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах</p>	<p>Жилдээ</p>	<p>МТШХХГ-аас 2014 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гарган, ХААГ-т хүргүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх</p> <p>Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах</p> <p>Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлах</p> <p>Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийн талаарх нээлттэй байдал</p> <p>Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийн нээлттэй байдал</p> <p>Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлангийн нээлттэй байдал</p> <p>Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх</p> <p>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх нээлттэй байдал</p> <p>Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байдал</p>	<p>МТШХХГ, Худалдан авах ажиллагааны газартай хамтран зохион байгуулж байгаа тендерийн урилгыг байгууллагын www.itpta.gov.mn цахим хуудсанд, мөн тус газраас эмхтгэн гаргадаг ITNEWS сэтгүүлийн дугаар болгонд бүрэн эхээр тухай бүрт нь гарган олон нийтэд нээлттэй мэдээлж байна.</p> <p>Салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төслүүдийн худалдан авах ажиллагааны тайланг сар, улирал, хагас болон жилийн байдлаар гаргаж, ЗГХЭГ, Сангийн яаманд тухай бүр хугацаанд тогтмол хүргүүлэн ажиллаж байна. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан</p>
8	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл; Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.8, 6.1.6</p>			
8.1	<p>Байгууллагын онцлогт тохирсон ёс зүйн хэм хэмжээг боловсруулж батлах</p>	<p>Жилдээ</p>	<p>Төрийн захиргааны албан хаагчын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах</p> <p>Нийт албан хаагчдад ёс зүйн дүрмийг мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулан гарын үсэг зуруулах</p> <p>Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлсэн байдал</p> <p>Зөрчлийн талаарх бүртгэл хөтлөлт</p> <p>Зөрчлийг хянан шийдвэрлэсэн байдал</p> <p>Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байдал</p>	<p>Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хуульд нийцүүлэн Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын албан хаагчийн ёс зүйн дүрмийг боловсруулан, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож дүгнэлт гаргах Тус газрын даргын 2013 оны 06 дугаар сарын 03-ний өдрийн 142 тоот тушаалаар эрх бүхий Ёс зүйн хороог байгуулан ажиллаж байна.</p> <p>Энэхүү хороо нь Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмыг тус тус баримтлан ажиллаж байна. Гадны байгууллага, иргэд болон газрын албан</p>

			Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлж, удирдлагад танилцуулах	хаагчдаас Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмээр хүлээсэн үүргийг биелүүлээгүй тухай аливаа гомдол санал тус газарт ирээгүй болно.
9	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх Эрх зүйн үндэслэл: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл			
9.1		Жилдээ	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулах	Байгууллагын цахим хуудас болон дотоод групп дээр давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт, түүний хэрэгжүүлэх журмыг байршуулаад байна.
			Албан тушаалтанд давхар ажил эрхлэлтийн талаар албан хаагчдын дунд судалгаа хийсэн байх	Тус газар болон харьяа газрын хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч, төлөөлөгчөөр сонгогдсон төрийн захиргааны алба давхар эрхэлж буй албан тушаалтаны судалгааг авч, тус газарт давхар ажил эрхэлж байгаа албан хаагч байхгүй болох талаар 2014 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 1/814 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.
10	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3; Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг			
10.1	Байгууллагын үйл ажиллагааны талаар санал, гомдол хүлээж авах чиг үүргийг бүтцийн нэгжид хариуцуулах	Жилдээ	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах	Монгол Улсад “Орчин цагийн харилцаа холбооны салбар үүсч хөгжсөний 93 жил”-ийн ой, “Цахилгаан холбоо, мэдээлэлжсэн нийгмийн Дэлхийн өдөр”-ийг тус тус тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд салбарын хэмжээнд уламжлал болгон 8 дахь жилдээ зохион байгуулж буй “ICT-EXPO-2014” үзэсгэлэн Мишээл экспо төвд 2014 оны 5 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд “Дэвшилтэт технологи-Ухаалаг хэрэглээ” уриан дор зохион амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэнд Мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа явуулж буй тэргүүлэгч 70 орчим аж ахуйн нэгж байгууллага, компаниудын зүгээс иргэдэд хүргэж буй үйлчилгээ, бүтээгдэхүүнүүдээ олон нийтэд танилцуулсан юм. Мөн үзэсгэлэнд Олон улсын болон гадаадын байгууллагууд, Мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан үйл ажиллагаа явуулж буй бусад салбарын байгууллагууд, Их дээд сургуулиуд, Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд оролцлоо.
			Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)	
			Иргэд, төр, хувийн хэвшлийн байгууллагаас ирсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийх /11-11 төв/	
			Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байдал	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчлах, бодлого, үйл

				<p>ажиллагааг танилцуулах, ажил үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг таниулах зорилгоор 2014 оны 10-р сарын 04-05-ны өдрүүдэд Чингисийн талбайд Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын нээлттэй өдөрлөг зохион байгууллаа. Тус өдөрлөгт Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд өөрийн компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах, техник технологийн шинэчлэлийн талаар иргэд, олон нийтэд таниулахаас гадна салбарынхан иргэдэд хэрэгтэй мэдээлэл зөвлөмжийг өгөхөөс гадна хөгжөөнт тоглоом, бүтээгдэхүүн үйлчилгээний хөнгөлөлт урамшуулал, мөнгөн дугаар, хүрэл дугаар, WIFI route зэрэг олон төрлийн бэлгийг үзэгчиддээ задлалаа.</p> <p>Тус газар нь сар бүр байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчлах зорилгоор IT news салбарын сэтгүүл, Мэдээлэл харилцаа холбооны салбарын статистик эмхэтгэл “Цагаан ном 2014” номны англи монгол хувилбарыг бэлтгэн гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Тус газарт иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах чиг үүргийг Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэнд хариуцуулан ажлын байрны тодорхойлолтод тусган ажиллаж байна.</p> <p>Шинэчлэлийн Засгийн Газар “11-11 ТӨВ”-ийн иргэдээс мэдээллийн технологийн чиглэлийн нийт 603 талархал, гомдол, шүүмжлэл, санал хүсэлт ирүүлснийг хүлээн авч, тухай бүрт нь шуурхай шийдвэрлэн, холбогдох арга хэмжээг авч, ажиллаж байна.</p> <p>Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэхтэй холбогдуулан санал, хүсэлтийн хайрцаг нээн ажиллуулж байна. Тус газарт 2014 оны 11 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд нийт 70 өргөдөл ирснийг хүлээн авч бүртгэн холбогдох албан тушаалтанд шилжүүлэн зохих хууль журмын дагуу шийдвэрлэлээ.</p>
11	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1			

11.1	Байгууллагын авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Жилдээ	МТШХХГ-ын авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах	<p>Байгууллагын албан хаагчдыг эрхэлж буй албан тушаалын байдал, худалдан авах ажиллагаанд оролцох байдалд нь судалгаа хийж, тус газрын авилгад өртөх эрсдэлтэй ажил, албан үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн гаргаж албан хаагчдад танилцууллаа. Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаа хууль тогтоомж болон холбогдох дүрэм, журамд нийцэж буй эсэхэд дотоод хяналт тавьж байна.</p> <p>Тус газарт албан тушаал, ажлын байрны тодорхойлолтонд уялдуулан удаан хугацаагаар ажилласан зарим албан хаагчдыг газар, хэлтэс дотор нь ажлын байрыг сэлгэн ажилуулж байна.</p>
			Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан/	

д/д	Хэлэлцүүлэх асуудлын агуулга	Хэлэлцүүлэх асуудлын үндэслэл (УИХ, Засгийн газрын шийдвэр)	
1	Төсвийн төлөвлөлт зарцуулалтын “Шилэн данс”-ны цахим системийн тухай Засгийн газрын тогтоолын төсөл	Төсвийн тухай хууль, МУ-ын Ерөнхийлөгчийн 2013 оны 188 дугаар зарлиг	
2	“Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын бодлогын баримтлах чиглэл-2020” баримт бичиг	Харилцаа холбооны тухай хууль	Ажлын хэсгийн хүрээнд МХХТ-ийн салбарын салбар дэд бүтцийн чиглэлийг тодорхойлон тус газрын холбогдох газар, хэлтсийн удирдлагуудаар ахлуулсан дэд ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Дэд ажлын хэсгүүд нь тухай чиглэлээр олон улсын болон дотоодын чиг хандлага, судалгаа хөгжлийн бодлого, UN – ITU – ын зөвлөмж зэргийг судлан өөрийн улсын МХХТ –ийн салбарын бодлогыг тодорхойлохоор бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж байна.
3	Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл	Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөр	“Өгөгдөл хамгаалах тухай” хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг олон нийтээр хэлэлцүүлэх зорилгоор нээлттэй хэлэлцүүлгийг Мэдээлэл технологийн үндэсний парсад 2014 оны 10 дугаар сарын 8-ны өдөр зохион байгуулав. Энэхүү хэлэлцүүлгээр хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагын өгөгдлийг хэрхэн боловсруулах, бүртгэх, ашиглах, хадгалах, дамжуулах, шилжүүлэх зэргээр мэдээллийн эргэлтэд

			оруулах процесстой холбоотойгоор үйлчилгээ эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлууд, түүний хуулийн зохицуулалтын талаар харилцан санал солилцлоо
4	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төсөл	Засгийн газрын 2010 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан “Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх” үндэсний хөтөлбөр	Хуулийн төслийн үзэл баримтлалын хэлэлцүүлгийг нээлттэйгээр 3 удаа хийсэн. Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжүүдийг төсөлд тусгасан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар ЗГХЭГ-т албан бичиг хүргүүлээд байна.
5	Олон улсын цахилгаан холбооны байгууллагын дүрмийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлуулах	Олон улсын гэрээний тухай хууль	Ажлын хэсгийн төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. УИХ-д хэлэлцүүлэхтэй холбогдсон бичиг баримтыг бүрдүүлж байна.
6	Төрийн цахим үйлчилгээний нийтлэг журам		Тус газрын даргын 2014 оны 227 дугаар тушаалаар журмыг батласан.
7	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл	Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөр	Тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг ажиллаж байна. Одоогийн байдлаар салбарын болон харьяа байгууллагуудаас ирсэн саналуудыг нэгтгэн өргөн барих төслийн драфтыг бэлтгэж байна. Мөн үзэл баримтлалын төсөл боловсруулж байна.
8	Шуудангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл		Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг ажиллан хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн төсөлд шинээр нэмэх 9 заалт, өөрчлөн найруулах 8 заалт, бичвэрт

			<p>өөрчлөлт оруулах 10, үндсэн өөрчлөлтөө дагаж өөрчлөх 7, хүчингүй болгох 1 заалт, нийтдээ 35 нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хүчин төгөдөр хуулийн 6 бүлэг, 12 зүйлийг хамарч байгаа болно. Эцэслэсэн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг авахаар ажиллаж байна.</p>
9	<p>Радио долгионы тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл</p>		<p>Нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг ажиллан салбарын болон харьяа байгууллагуудаас саналуудыг авч нэгтгэн төслийг бэлэн болгосон. Эцэслэсэн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг авахаар ажиллаж байна.</p>
10	<p>Дэлхийн шуудан холбооны дүрмийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлуулах</p>	<p>Олон улсын гэрээний тухай хууль</p>	